

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН МОНГОЛ
УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИУДЫН ТӨСӨЛД
ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ
ДҮГНЭЛТ**

Улаанбаатар хот

2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” болон “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2-д заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-өөс дараах дүгнэлтийг өгч байна.

Нэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх дүгнэлт

- 1.1. Төсвийн бодлогын чиглэл бодит байдалд нийцэх хандлагатай болж байна.** Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 2025 онд 30,209.9 тэрбум төгрөг, 2026 онд 31,720.4 тэрбум төгрөг, 2027 онд 33,761.0 тэрбум төгрөг, нийт зарлагыг 2025 онд 31,775.1 тэрбум төгрөг, 2026 онд 32,839.8 тэрбум төгрөг, 2027 онд 34,626.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 онд ДНБ-ий 33.6 хувь, 2026 онд 30.9 хувь, 2027 онд 29.3 хувь, харин нийт зарлага 2025 онд ДНБ-ий 35.1 хувь, 2026 онд 32.0 хувь, 2027 онд 30.0 хувь болж үе шаттай буурахаар тооцсон байна (МУЗГ, 2025.06.25). Энэ нь өнгөрсөн жилүүдэд хэт тэлсэн төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлахад чиглэж, дэлхий нийтийн болон Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн бодит нөхцөл байдалд нийцсэн гэж ТТБЗ үзэж байна.
- 1.2. Хямралтай гэж тооцсон үеийн ДНБ-ий бодит өсөлт, нэрлэсэн хэмжээ зөвлөлөөс өмнө гаргасан төсөөлөлтэй ойролцоо байна.** ТТБЗ-өөс 2024, 2025 оны 3 дугаар сард Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал”-ын тайландаа макро эдийн засгийн таамаглал, тооцооллыг тусгасаар ирсэн ч Засгийн газрын зүгээс ДНБ-ий бодит өсөлт болон нэрлэсэн хэмжээг ТТБЗ-ийн төсөөллөөс өндрөөр тооцож, УИХ-аар батлуулж ирсэн.

Хүснэгт 1. МУНТ-ийн 2025 оны ТХМ-д тусгагдсан зарим үзүүлэлтийн харьцуулалт


Үзүүлэлтүүд	УИХ-аар 2024.12.12-нд баталсан ТХМ	ТТБЗ-ийн боловсруулсан таамаглал, 2025 оны 3-р сар	МУЗГ, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2025 оны 4-р сар	МУЗГ, Өргөн барьсан төсөл 2025 оны 6-р сар
Эдийн засгийн өсөлт, хувь	8.0	5.4	7.5	5.5
Нэрлэсэн ДНБ, их наяд төгрөг	95.0	88.6	93.0	90.0
Инфляц, хувь	7.2	8.8	9.9	9.5
МУНТ-ийн тэнцвэржүүлсэн орлого, ДНБ-д эзлэх хувь	35.2	36.9	35.2	33.6
МУНТ-ийн зарлага, ДНБ-д эзлэх хувь	35.2	38.9	35.2	35.1
МУНТ-ийн тэнцвэржүүлсэн тэнцэл, ДНБ-д эзлэх хувь	0	-2.0	0	-1.5
Засгийн газрын өр, ДНБ-д эзлэх хувь	55.0	57.0	42.1	55.0

Эх сурвалж: ТТБЗ, МУЗГ

Засгийн газар “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2025 оны эдийн засгийн өсөлтийг 7.5%-аас 5.5% болгон бууруулсан нь ТТБЗ-ийн 2025 оны 3-р сард гаргасан төсөөлөлтэй ойролцоо байна (Хүснэгт 1).

- 1.3. **Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн тодотголын төсөлд төсвийн зарлагыг 4.6 хувиар бууруулсан ч Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага Колин Кларкийн критик хязгаарыг давсан хэвээр байна.** Английн эдийн засагч Колин Кларк ДНБ-д эзлэх төсвийн зардал 25%-аас дээш гарсан үед төсөв баланстай байсан ч инфляцыг өдөөдөг болохыг 1945 онд судлан тогтоожээ¹. Монгол Улсад 1997 оноос эхлэн төсвийн зардал Кларкийн хязгаарыг тогтмол давсан байдалтай байна. Төсвийн зарлага ба инфляцын хувьд 2000-2024 онд дундаж инфляц 8.8%, ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь дунджаар 34%, урсгал зардлын эзлэх хувь дунджаар 25% байжээ.

Зураг 1. Монгол Улсын төсвийн зарлага, инфляцын хамаарал



Эх сурвалж: ТТБЗ-ийн 2025 оны таамаглалын тайлан

- 1.4. **Төсвийн орлогын өөдрөг төсөөллийн алдаанаас үүдэн төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах нөхцөл үүссэн байна.** ТТБЗ-өөс 2024-2025 онд дунд хугацааны ТХМ, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголд өгсөн дүгнэлтдээ Засгийн газар төсвийн орлогын төсөөллийг хэт өөдрөгөөр хийж байна гэж сануулсаар ирсэн билээ. Үүнийг дараах хүснэгтээс харж болно. Төсвийн орлогыг гадаад, дотоод орчны эрсдэлийг харгалзан үндэслэлтэй тооцож байсан бол ТХМ-д өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй байх нөхцөл бүрдэхээр байв.

Хүснэгт 2. ТТБЗ-өөс өгсөн дүгнэлтэд орлогын төсөөллийн талаар тусгасан байдал

Дүгнэлт өгсөн төсвийн баримт бичиг	Огноо	Дүгнэлтийн агуулга
МУНТ-ийн 2025 оны ТХМ, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд өгсөн дүгнэлт	2024.05.02	... төсвийн орлого, зарлага ихээхэн нэмэгдэхээр тооцсоноос үзвэл мөчлөг дагасан төсвийн бодлогыг цаашид хэвээр хадгалахаар байна.
Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт	2024.09.20	... Өнөөгийн байдлаар дотоод эдийн засгийн нөхцөл байдал сайн байгаа боловч төсвийн орлогын төлөвлөлт нь гадаад орчин, эрсдэлт хүчин зүйлсийг багасгаж, харин нөхцөл байдлыг хэт өөдрөгөөр харсан, мөчлөг дагасан байдал хэвээр үргэлжлэх ... чиглэлтэй байгааг анхаарах.

¹ Colin Clark, "Public Finance and Changes in the Value of Money", *The Economic Journal*, Vol. 55, No. 220 (December 1945), pp. 371–389.

- 1.5. **Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл зах зээлийн нөхцөл байдлыг үл харгалзан өндөр хэвээр байна.** Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 2025 онд 129 ам.доллар байхаар, харин зах зээлийн үнийг 72 ам.доллар байхаар тооцжээ. Засгийн газар нэгдсэн төсвийн орлогыг бүрдүүлэх гол эх үүсвэр болох нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тооцохдоо ОУВС-аас гаргадаг түүхий эдийн үнийн мэдээллийг ашиглан Австрали, Өмнөд Африкийн нүүрсний үнийг хамруулсан нүүрсний үнийн индексийн дунжийг авч ашиглажээ. Энэ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг өндрөөр тооцоход голлон нөлөөлж байгаа учир гол нэрийн түүхий эдийн үнийг тэнцвэржүүлсэн үнээр тооцох аргачлалыг эргэн харж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгож байна.
- 1.6. **Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагыг 1.8 их наяд төгрөгөөр бууруулсан нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна.** Сүүлийн жилүүдэд төсөв төвтэй эдийн засгийн бүтэц үүсгэсэн тул төсвийн зарлагыг бууруулснаас үүсэх орон зайг хэрхэн нөхөхийг хуулийн төслийн танилцуулга, тооцоололд тодорхой тусгаагүй байгаа юм. Төсвийн таналтаас эдийн засагт ирэх нөлөөллийг үндэслэлтэй тооцож, завсрын дамжлага үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага тулгардаг тул төсвийг зарлагыг хангалттай хэмжээнд хасахгүй байх шалтгаан ч болох магадлалтай. Иймд төсвийн зарлага, ялангуяа хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэснээр эдийн засагт үзүүлэх үр дагаврыг нарийвчлан тооцоход анхаарах хэрэгтэй болно.
- 1.7. **Өрийн төсөөлөл анхаарал татахуйц байна.** Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын нэрлэсэн үнээр илэрхийлэгдсэн нийт өрийн ДНБ-д эзлэх хувь өмнө батлагдсан хэмжээнд буюу 55 хувь хэвээр байхаар тооцжээ. Гэвч эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж, төсвийн нийт тэнцэл 1.36 их наяд төгрөгийн алдагдалтай болсон байхад өрийн нийт хэмжээг 2.7 их наяд төгрөгөөр багасна гэж тооцсон байна.

Хоёр. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх дүгнэлт

- 2.1. **Дунд хугацаанд макро эдийн засгийн төсөөллийг “хазайхгүй, рационал, онодог байх” зарчмуудыг баримтлан боловсруулахгүй байна.** Суурь буюу 2025 оны төсөвт өөрчлөлт орсны улмаас дунд хугацаанд баримтлахаар баталсан бодлогын баримт бичигтээ “он дамжсан” өөрчлөлтийг хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Өргөн барьсан төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 2026 онд 31,720.4 тэрбум төгрөг, 2027 онд 33,761.0 тэрбум төгрөг, 2028 онд 35,856.6 тэрбум төгрөг, нийт зарлагыг 2026 онд 32,839.8 тэрбум төгрөг, 2027 онд 34,626.0 тэрбум төгрөг, 2028 онд 36,428.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 онд ДНБ-ий 30.9 хувь, 2027 онд 29.3 хувь, 2028 онд ДНБ-ий 27.6 хувь, харин нийт зарлага 2026 онд ДНБ-ий 32.0 хувь, 2027 онд 30.0 хувь, 2028 онд 28.0 хувь болж үе шаттай буурахаар тооцжээ. Гэвч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлэн тэнцлийг 2026 онд ДНБ-ий -1.1 хувь, 2027 онд -0.7 хувь, 2028 онд -0.4 хувийн алдагдалтай байхаар тооцож тусгасан байна (МУЗГ, 2025.06.25).
- 2.2. **Нэг тодотголыг дагаж хоёр төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдөж байна.** Төсөв дагаж өөрчлөгдсөөр ирсэн төсвийн хүрээний мэдэгдэл нь тодотгол даган өөрчлөгдөж

байгаа бөгөөд тухайн оны 6 дугаар сараас хойш хийгдэж буй төсвийн тодотголын хамт энэ онд батлагдсан дараагийн 3 жилийн ТХМ-д өөрчлөлт ордог болж байна.

2.3. Батлагдсан дунд хугацааны ТХМ-д өөрчлөлт оруулах зохицуулалтыг ТТБТХ-д хангалттай тусгаагүй байна. Дунд хугацааны ТХМ-д өөрчлөлт оруулах тохиолдолд хуулийн төслийг өргөн барихдаа ТТБТХ-ийн 16¹.6 дахь заалтад “Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг энэ хуулийн 16¹.5.1-д² заасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулаагүй бол түүний үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлж тайлбарлан, уг тайлбарыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хамт өргөн мэдүүлнэ” гэсэн заалтыг баримтлах эсэх нь тодорхойгүй, нарийвчлан зохицуулсан зүйл тусгаагаагүй байгаа юм.

ЗӨВЛӨМЖ

- Төсвийн тухай хууль тогтоомжид дараах эрх зүйн өөрчлөлтийг хийх хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:
 - Гол нэрийн түүхий эдийн үнийг тэнцвэржүүлсэн үнээр тооцох аргачлалыг олон улсын санхүүгийн байгууллагаас мэдээлж буй үнээс гадна Монгол Улсаас экспортолж буй зах зээлийн үнэд тулгуурлан тооцож байхаар өөрчилж хуульчлах;
 - ТХМ-д өөрчлөлт хийхтэй холбоотой зохицуулалтыг ТТБТХ-д нэмж оруулах;
 - ТТБТХ-ийн 12.3-т тусгагдсан дунд хугацааны ТХМ-ийн үндсэн есөн үзүүлэлтээс “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ” гэсэн үзүүлэлтийг тооцож, хэлэлцэж болох ч хуульчлан батлахгүй байх нь төсвийн орлого, зарлагыг бууруулах байдлаар төсөвт тодотгол хийх тохиолдолд ТХМ-д өөрчлөлт оруулах нөхцөл үүсэхгүй болно гэдгийг харгалзан үзэх.
- Цаашид макро эдийн засгийн төсөөллийг “хазайхгүй, рационал, онодог байх” зарчмуудыг баримтлан боловсруулах зайлшгүй шаардлага үүсэж байгааг анхаарч ажиллах.
- ТХМ-ийн үндсэн есөн үзүүлэлтийн тооцоолол, төсөөллийг өөр хоорондоо нийцтэй байхаар боловсруулдаг байх. Тухайлбал, 2025 оны төсвийн тэнцэл алдагдалтай болох үед Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувийг хэвээр хадгалж, харин нийт өрийн дүнг төсвийн алдагдлын хэмжээнээс хоёр дахин илүү хэмжээгээр бууруулж буй нь эргэлзээтэй юм.
- Эдийн засаг дахь төрийн оролцоо буюу ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувийг багасгах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэхийн тулд уг бодлогын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцсон стратегийг боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

----- о О о -----

² 16¹.5.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал боловсруулах;